



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/56

Бат-Өлзий сум

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мод үржүүлгийн газарт инженерийн хийцтэй гүний худаг (цооног) гаргах ажлыг “Баян говь ус” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. “Баян говь ус” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Мод үржүүлгийн газарт инженерийн хийцтэй гүний худаг (цооног) гаргахад шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг гэрээний дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

